

Ерөнхийлөгч
Томас С.Монсон



Гэрэл болон ЗОГСОХ НЬ

Ариун сүмийг онцгойлон адислахтай холбоотой урлаг соёлын олон тэмдэглэлт үйл ажиллагаанд оролцох боломж надад тохиодог билээ. Тэдгээр нь бүгдээрээ төдийгүй хамгийн сүүлд өнгөрсөн оны 11-р сард АНУ-ын Аризона мужийн Фийникст болсон үйл ажиллагаа надад маш их таалагдсан юм.

Урлаг соёлын үйл ажиллагаанд оролцсон өсвөр үеийн хожмын үеийн гэгээнтнүүд гайхалтай, мартагдашгүй хөтөлбөрийг зохион байгуулаа. Би өнгөрсөн жилийн Фийникст болсон үйл ажиллагаа эхлэхийн өмнөхөн тэдгээр хүүхдүүдэд хандан “Та нар бол гэрлийн хүүхдүүд” гэж хэлж билээ.

Би Сүмийн бүх өсвөр үеийнхнийг гэрлийн хүүхдүүд гэдгээ мэдээсэй хэмээн хүсэж байна. Тиймээс тэд “дэлхийн гэрэл” (Филиппой 2:15) байх үүрэг хариуцлагатай билээ. Тэд сайн мэдээний үнэнийг хуваалцах үүрэгтэй. Тэд улам бүр харанхуйлж байгаа дэлхийд сайн мэдээний гэрлийг тусгах, ариун сүмийн гэрэлтүүлэгч болон зогсох дуудлагатай юм. Гэрлээ бадрангуй, хурцаар ассан хэвээр байлгах цэнэг тэдэнд байгаа.

Бид “итгэгч хүмүүст үлгэр дуурайл” (1 Тимот 4:12) үзүүлэхийн тулд өөрсдөө итгэх ёстой. Сүнслэгээр оршин тогтнож, бусдад гэрэл тусгаж өгөхөд шаардлагатай итгэлийг бид хөгжүүлэх ёстой юм. Бид гэрчлэлээ амьдралынхаа зангуу болох хүртэл өсгөн тэтгэх хэрэгтэй.

Өнөөдөр бидэнд хэрэгтэй итгэлийг олж авах, хадгалан үлдэх үр дүнтэй аргууд бол судруудыг уншиж,

судлах болон ойр ойрхон тууштай залбирах явдал юм. Сүмийн өсвөр үеийнхэнд хандан хэлэхэд, хэрэв та нар эдгээрийг хийхгүй байгаа бол одооноос эхлэн өдөр бүр судраас суралцан, залбирах дадлыг хөгжүүлээрэй. Энэ үндсэн хоёр дадлыг эзэмшихгүй бол гадны нөлөө, заримдаа амьдралын нугачаа та нарын гэрлийг бүүдийлгэж, бүр унтрааж ч чадна.

Өсвөр насны он жилүүд амаргүй байдаг. Энэ бол та нарыг тэнгэрлэг гэртээ эргэн очиход чиглүүлдэг замаас тань хазайлгахар Сатаны уруу татах, хамаг хүчээрээ хичээх чухал үе нь юм. Харин та нар уншиж, залбирч, үйлчилж мөн дуулгавартай байвал “харанхуйд гялалзагч гэрэл” (С ба Г 6:21), бидний Жишээ Үзүүлэгч, эрч хүч— Их Эзэн Есүс Христийг илүү сайн мэдэж авах болно. Тэрээр түнэр харанхуйг гэрэлтүүлэхээр бидний өргөх тэрхүү Гэрэл билээ (3 Нифай 18:24-ийг үзнэ үү).

Аврагчийн болон Түүний сэргээгдсэн сайн мэдээний талаарх баттай гэрчлэлтэй байх үед та нарт гэрэлтэх хязгааргүй боломж байх болно. Ямар ч нөхцөлд байсан, тэдгээр боломж нь өдөр бүр та нарыг хүрээлэн байдаг. Аврагчийн жишээг дагах үед та нарын эргэн тойронд байдаг гэр бүлийн гишүүд, ангийнхан, ажлын хамт олон, зүс таних эсвэл огт танихгүй хүмүүсийн амьдралд гэрэл нь болох боломж та нарт байх болно.

Та дэлхийн гэрэл нь байх үед эргэн тойрны хүмүүс тантай нөхөрлөж, таны жишээг дагах хүслийг тэдэнд төрүүлэх онцгой сүнсийг мэдрэх болно.

Өсвөр үеийнхний эцэг эх, удирдагчдаас үнэн ба зөв шударгын төлөө бат зогсоход нь тэдэнд туслаасай хэмээн би чин сэтгэлээсээ хүсэж байна. Суралцах, ойлгон ухаарах, Бурханы хаант улсад үйлчлэх үүд хаалгыг тэдний мэлмийд өргөн дэлгэр нээж өгч тусал. Дэлхийн уруу таталтуудыг сөрөн зогсох хүчийг тэдэнд бий болгож өгөөрэй. Ариун журамд болоод итгэлд алхах, залбиралтай байх мөн байнгын зангуу нь болох тэнгэр рүү харах хүслийг тэдэнд өгөөрэй.

Би өсвөр үеийнхэндээ хандан Тэнгэрлэг Эцэг та нарт хайртай гэдгийг хэлье. Мөн та бүхнийг хайрлах Сүмийн удирдагчдынхаа хайрыг мэдрээрэй. Тэнгэрлэг Эцэгт болон Түүний Хүүд үйлчлэх хүслийг үргэлж тээж яваарай. Үргэлж үнэнд алхаж, Бурханы хүүхдүүдийн дунд гэрэл нь болж зогс.

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

“Гэрлийн [хүүхэд]” байна гэдэг нь ямар утгатай болохыг заах хүмүүстэйгээ ярилцах талаар бодож үз. Энэ нь ямар үүрэг хариуцлагыг бий болгодог вэ? Тэдний гэрэл онцгой тод байсан үеийг болон юунаас болоод тийм тод гэрэлтэж байсан талаар ярилцаж болно. Тэднээс гэрэл хэрэгтэй байж болох өсвөр үеийн хүүхэд, хамт ажилладаг хүн эсвэл гэр бүлийн гишүүн зэрэг хэн нэгэн хүний талаар бодохыг хүс. Дараа нь түүнтэй гэрэл хуваалцах арга замын төлөө хамтдаа залбирч болно.

© 2015 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/15. Орчуулгын зөвшөөрөл: 6/15. *First Presidency Message, August 2015-ын орчуулга*. Mongolian. 12588 363

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД

Гэрэлтүүлэгч гэрэл

Ерөнхийлөгч Монсон Сүмийн өсвөр үеийнхэн “улам бүр харанхуйлж байгаа дэлхийд сайн мэдээний гэрлийг тусгах, ариун сүмийн гэрэлтүүлэгч болон зогсох дуудлагатай” хэмээн заасан. Тэрээр үүнийг хийж болох хэд хэдэн арга зааж өгсөн билээ:

Сайн мэдээг хуваалцах

Итгэх

Итгэлээ хөгжүүлэх

Бусдад гэрэл нь болох

Гэрчлэлээ амьдралынхаа зангуу болтол өсгөн хөгжүүлэх

Судруудыг уншиж, судлах

Ойр ойрхон, тууштай залбирах

Үйлчлэх

Дуулгавартай дагах

Эдгээр зүйлээр өөрийгөө 1-ээс 5-ын хооронд дүгнэж болно. Бага оноотой хэсгүүдийнхээ сэдвийг судраас эсвэл LDS.org дээрээс хайн, судал. Эдгээр сэдвийг судалсныхаа дараа тухайн хэсгүүд дээр хэрхэн хүчирхэгжиж болох арга замуудыг бодож олон, зорилго тавьж болно.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Гэрлээ гийгүүл

Бурханы хүүхдийн хувьд чи гэрлийн хүүхэд билээ. Чи Аврагч Есүс Христийг дагаснаар гэрлээ нэмэгдүүлж чадна. Есүс Христ, Тэнгэрлэг Эцэг хоёр чамд хайртай бөгөөд чамайг бусдыг гэрэлтүүлж, Христ рүү хөтлөөсэй хэмээн хүсдэг. Би залбирах, судраас унших зэргээр зарлигуудыг дагахдаа өөрийнхөөрөө байж гэрэлтэж чадна. Цаасан дээр оддыг зураад, дээр нь Есүс Христийн жишээ болохын хувьд чи бусдыг хэрхэн гэрэлтүүлж болох санаануудыг бич (жишээ нь, “сүмдээ явах” эсвэл “гэр бүлдээ туслах” гэх мэт).



Есүс Христийн тэнгэрлэг зан чанар: Дөлгөөн мөн даруухан

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ олж мэдэхийг эрэлхийл. Аврагчийн амьдрал, зорилгыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлж мөн айлчлагч багшийн хувьд харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг хэрхэн адислах вэ? Нэмэлт мэдээлэл авах бол reliefsociety.lds.org хаягаар орж үзнэ үү.

Итгэл, гэр бүл, халамж

Энэ бол Аврагчийн тэнгэрлэг зан чанарын талаарх Айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

Есүс “Та нарын дотроос хамгийн Агуу нь хамгийн өчүүхэн нь мэт болог, удирдагч нь зарц мэт байг. Ширээнд тухлагч, үйлчлэгч хоёрын хэн нь агуу вэ? Ширээнд тухлагч нь биш гэж үү? Харин Би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг” (Лук 22:26-27) гэж хэлсэн.

“Аврагч бол бидний даруу хийгээд хүлцэнгүй байдлын хамгийн дээд жишээ билээ. Эцэст нь Өөрийн хүслийг Эцэгтээ захируулсан нь бүхий л түүхэн дэх хамгийн агуу, хамгийн хүчирхэг үйл явдлыг авчирсан юм. Судруудахь хамгийн ариун нандин үгсийн нэг нь ‘Миний хүсэл бус, харин Таны хүсэл биелэгдэг’ (Лук 22:42) хэмээх юм.”¹

Есүс Христийн шавь нарын хувьд бид үргэлж Түүнтэй адилхан болохыг хичээдэг. “Бид Христтэй илүү адилхан болоход хүлцэнгүй байдал нэн чухал байдаг” гэж Далын ахлагч Үлиссэс Соарэс хэлжээ. Хүлцэнгүй байдалгүйгээр бид бусад чухал шинж чанарыг хөгжүүлэх боломжгүй. Хүлцэнгүй байх гэдэг нь сул дорой байхыг хэлдэггүй, харин эелдэг байж,

сайхан сэтгэл гарган, өөрийн хүчтэй тал, тайван дөлгөөн байдал, өөртөө хүндэтгэлтэй хандах хийгээд өөрийгөө хянах чадвараа харуулахыг хэлдэг.”² Энэхүү зан чанарыг хөгжүүлэх явцдаа бид “өөрсдийн хүслийг Эцэгт даруунаар захируулах нь Бурханы эрх олгох буюу даруу байдлын хүчийг авчирдаг болохыг олж мэддэг. Энэ нь амьдралын саад бэрхшээлтэй нүүр тулах хүч, амар амгалангийн хүч, найдварын хүч, Аврагч Есүс Христийг хайрлах хайр болон Түүний талаарх гэрчлэлийн сэтгэл догдуулам хүч, бүр гэтэлгэлийн хүч билээ.”³

Нэмэлт судрууд

Матай 26:39; Иохан 5:30;
Мозая 3:19; Хиламан 3:35

Судруудаас

Христийн тохинууллын хамгийн нандин бөгөөд хүчирхэг мөчүүдийн нэг бол Тэрээр дагалдагчдынхаа хөлийг угаасан нь юм. “Тэр зоогийн ширээнээс босож, гадуур хувцсаа тайлаад, алчуур авч бүслэв. Тэгээд саванд ус хийж, шавь нарынхаа хөлийг угаагаад, бүсэлсэн алчуураараа арчиж эхлэв” (Иохан 13:4-5).

Аврагчийг энэхүү ёслолыг үйлдэхэд Их Эзэн, Багш нь өөрсдийнх нь өмнө сөхрөн сууж, маш хүлцэнгүй даруу үйлчлэл үзүүлсэнд дагалдагчид нь мэгдэн сандарч байсан болов уу. Дараа нь Есүс тэднийг болон биднийг сураасай хэмээн хүсэж байсан сургамжаа:

“Тэгвэл Би Эзэн, Багш байтлаа та нарын хөлийг угаасан бол та нар мөн нэг нэгнийхээ хөлийг угаах ёстой.

Учир нь Миний та нарт юу хийснийг та нар бас хийх хэрэгтэй гэж Би ийм жишээ үзүүлсэн юм” (Иохан 13:14–15) хэмээн айлдсан.

Эшлэлүүд

1. Ричард С.Эджлий, “Даруу байдлын эрх олголт,” *Liahona*, 2003 оны 11-р сар, 99.
2. Үлиссэс Соарэс, “Хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэдээ номхон байгтун,” *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 9.
3. Ричард С.Эджлий, “Даруу байдлын эрх олголт,” 99.

Үүнийг эргэцүүлэн бод

Даруу байх нь Аврагчтай адил бусдыг хайрлахад бидэнд хэрхэн туслах вэ?